



НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 7/82

Улаанбаатар хот

Л.Дамдинсүрэнгээр зарим ажил үйлчилгээг
гэрээгээр гүйцэтгүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2003 оны “Төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх тухай” 233 дугаар тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны “Гэрээгээр гүйцэтгүүлэх албан тушаал, ажил үйлчилгээний жагсаалт батлах тухай” Б/478 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Лувсандоржийн Дамдинсүрэнг тус газрын Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст гэрээт ажилтан /архивын баримт бичиг хариуцан ажиллах/-аар 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн гэрээ байгуулж, томилсугай.

2. Л.Дамдинсүрэнгийн нэг сарын цалинг 500000 /таван зуун мянга/ төгрөг, хоол унааны нөхөх төлбөрийг холбогдох журмын дагуу тооцож олгохыг Захиргааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт зөвшөөрсүгэй.

3. Л.Дамдинсүрэнгийн ажил хүлээлцсэн тухай тэмдэглэлийг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дотор Захиргааны хэлтэст ирүүлэхийг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Мөнгөнсүхэд үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттөмөрт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.АНХНЫБАЯР



001140500397